БАТЛАВ.

АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ Л.ЭНХБАЯР

ХОВД АЙМГИЙН ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ТӨВИЙН НЭГДСЭН ЦЭВЭР БОХИРЫН ГАДНА ШУГАМ СҮЛЖЭЭ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 он 05 сарын 27 Ховд хот

1.Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг " Алсын хараа 2050" -Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө -Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолын хавсралт -Ховд аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр -Эрдэнэбүрэн сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
3.Барилга байгууламжийн байршил	Ховд аймаг Эрдэнбүрэн сум
3. Зориулалт хүчин чадал	-Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаатай холбогдуулан сумын төвийн Шинэ суурьшлын бүсэд өөрчлөлт орсноор бохир усны шугамын трасс, цэвэрлэх байгууламжийн байрлал өөрчлөгдсөн. Үүнтэй уялдуулан 2019 онд батлагдсан зураг төсөлд өөрчлөлт оруулан нэмэлт ажлууд шинээр хийхээр төлөвлөв. 2019 онд батлагдсан төсөвт цалингийн болон материалын үнийн зөрүүг тооцож шинэчлэх
4. Хамрах хүрээ	Төлөвлөлт хийх газрын хязгаарыг захиалагч болон орон нутагтай харилцан тохирно.
5.Хэрэглэгчийн ачаалал	-Байр зүйн болон дэвсгэр зураг -Шинээр нэмэгдэх бохир усны шугамын урт 1,5км орчим -Шинээр хийгдэх цахилгааны шугамын урт 1,5 км КТПН -Цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэлт
6. Зураг төсөл боловсруулахад баримтлах үндсэн норм дүрэм	Монгол Улсын хуулиуд: - Хот байгуулалтын тухай - Барилгын тухай - Газрын тухай хууль - Хот суурин газрын ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хууль - Эрчим хүчний тухай - Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай - Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай Норм, норматив стандарт - Ариутгах татуурга ,Гадна сүлжээ ба байгууламж БД40-01-14 (БХБ-ын сайдын 2014 оны 90 дугаар тушаал) - Ус хангамж, Гадна сүлжээ ба байгууламж БД40-02-16 (БХБ-ын сайдын 2016 оны 116 дугаар тушаал)

7. Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	-2019 онд хийгдсэн ариутгах татуургын гадна шугам сүлжээний зураг төсөл Шинээр нэмэгдсэн суурьшлын бүсийн байр зүйн болон дэвсгэр зураг Инженер-геологийн судалгааны дүгнэлт, хавсралт материалууд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг
8. Үе шат, хугацаа	1 үе шаттай байна. Ажлын зураг төслийг бүрэн дуусган магадлалаар баталгаажуулан хүлээлгэн өгөх
9. Зураг төслийн байгууллага	- Эрх бүхий байгууллага
7.Хөрөнгө оруулалт	- Орон нутгийн төсөв
Онцгой нөхцөл	-Шаардлагатай тохиолдолд ашиглагч, захиалагч байгууллагын саналаар шугам сүлжээний ажлын тоо хэмжээг нэмж болно. -Барилгын салбарт мөрдөж байгаа Барилгын тухай хууль, Хот суурины хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах зөвшилцөх магадлал хийх дүрмийг баримтлан боловсруулах -Ус хангамж, ариутгах татуургын системийн угаалт, шахалт, туршилт, тохируулллагын ажлын зардлыг төсөвт тусгах -Бохир усны шугамын угсралтын ажлын үед газар доорхи шугам сүлжээг зөөх, авто замыг сэргээх, шугамыг шилжүүлэхэд гарах зардлыг төсөвт тусгах -Шугаман байгууламжийн трассын дагуух газрын зураглал нь М 1:1000 байна. -Цэвэрлэх байгууламжийн технологийг орчин үеийн дэвшилтэт технологи бүхий цэвэрлэгээний түвшин өндөр, байгаль орчинд ээлтэй эдийн хэмнэлттэй технологиор сольж шинэчлэх
Эдийн засгийн тооцоо, төсөв	Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцно
Захиалагчийн нэр хаяг утас	Аймгийн ЗДТГазар, Эрдэнэбүрэн сумын ЗДТГазар

ХЯНАСАН:

БОНХОБТХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.АНХБАЯР

ГХБХБГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ШИНЭЗОРИГ

"ШИМ-УС" ОНӨААТҮГАЗРЫН ДАРГА Я.ГАНЗОРИГ

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА Ц.АЛТАНГЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:

БОНХОБТХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН М.БАЯРЖАРГАЛ

ГХБХБГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ӨНӨРЖАРГАЛ

"ШИМ-УС" ОНӨААТҮГАЗРЫН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР О.БАДАМЦЭЦЭГ

ХОВД АЙМАГ
ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГА

84180 Хар ус,Эрдэнэбүрэн сум, Ховд аймаг
E-mail:erdeneburen_zdtg@khovd.gov.mn

2025. 03. 21 № 1/63

танай _____-ны №_____-т

"ДӨРВӨНГҮН" ХХК-Д

Тус сумын нэгдсэн цэвэр бохир усны шугам сүлжээний зураг (DG-103/2018) төсвийг 2018 онд танай компани хийсэн ба уг төсөл нь хэрэгжиж эхлэх болсонтой холбогдуулан цэвэрлэх байгууламжийн зурагт өөрчлөлт оруулан цэвэрлэгээний үр дүн өндөр, ашиглалтын зардал бага, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий цэвэрлэх байгууламж байхаар шинэчлэн өөрчилж өгнө үү.

Жич: Шинээр төлөвлөсөн цэвэрлэх байгууламжийн газрын байршил, кадастрын зургийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт ... хуудастай.

Ц.АЛТАНГЭРЭЛ

84180 05 084

А5 тоот

ХОВД АЙМАГ
ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГА

84180 Хар ус,Эрдэнэбүрэн сум, Ховд аймаг
E-mail:erdeneburen_zdtg@khovd.gov.mn

2025.03.21 № 1/61

танай _____-ны №_____-т

"ДӨРВӨНГҮН" ХХК-Д

Тус сумын нэгдсэн цэвэр бохир усны шугам сүлжээний зураг (DG-103/2018) төсвийг 2018 онд танай компани хийсэн ба уг төсөл нь хэрэгжиж эхлэх болсонтой холбогдуулан уг ажлын төсвийн тооцоог шинэчлэн баталгаажуулж өгнө үү.

Ц.АЛТАНГЭРЭЛ

84180 05 032

АБ тоот

ХОВД АЙМАГ
ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 27 өдөр Дугаар А/102 Хар ус

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 59.1.17 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1, сумын ИТХ-ын 2019 оны 04/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших хүсэлт гаргасан Засаг даргын тамгын газарт Сумын төвийн хогийн цэгийн хойд талд Цэвэрлэх байгууламжийн зориулалтаар 1225 м2 газрыг 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрх авсан Засаг даргын тамгын газартай гэрээ хийж, эрхийн гэрчилгээ, кадастрын зурагаа хэвлэн авах эрх үүсгэхийг Газрын даамал Б.Дэлгэрдалайд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА У.ЦЭРЭНТОГТОХ



Зургийн масштаб = 1:500 (1 сантиметрт 5 метр багтана)

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын цэвэрлэх байгууламж барихад шаардалагтай газрын байршил

Солбицлцын цэгүүд

№	X	Y	Урт
1.	386541.4465	5374540.8137	35.00
2.	386522.8994	5374511.1320	35.00
3.	386552.5810	5374492.5848	35.00
4.	386571.1282	5374522.2665	35.00

Талбайн хэмжээ: 1225 квадрат метр

БАТЛАВ:
ХОВД ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ГАНТӨМӨР

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар:24

2025 оны 03 сарын 19 өдөр Ховд аймаг, Жаргалант сум

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	**Хүсэлтийн дугаар:**	2025.03.21
1.2	**Хэрэглэгчийн нэр:**	Эрдэнэбүрэн сум ЗДТГ
1.3	**Регистрийн дугаар:**	9067434
1.4	**Утасны дугаар:**	88888505
1.5	**Техникийн нөхцлийн чиглэл:**	Гадна ариутгах татуургын шугам сүлжээ
1.6	**Хэрэглэгчийн байршил:**	Ховд аймаг Эрдэнэбүрэн сум 3-р баг Хонгой багийн улааны ард 8418000612 нэгж талбарын дугаартай 1225 м2 талбай бүхий Үйлдвэрлийн зориулалттай өмчлөх газар
1.7	**Техникийн нөхцөл олгох үндэслэл:**	Эрдэнэбүрэн сум ЗДТГ-ийн 2025 оны 03-р сарын 21 нд ирүүлсэн хүсэлтийг үндэслэн.
1.8	**Техникийн нөхцөлийн ангилал:**	Шинэ холболт
1.9	**Тооцооны чадал:**	90 кВт

Хоёр.Холболтын цэг:

2.1	35/0,4 кВ-ын Эрдэнэбүрэн дэд станцын 6 кВ Сумын төв фидер гаргалгааны 6кВ-ын ЦДАШ эхлэлийн тулгуураас холболт хийх.
2.2	Холболт хийх тулгуураас 30м зайд анкер тулгуур босгон салбар шугамын эхний тулгуурт хуурай салгуур суурилуулан бүрээстэй агаарын шугам татаж шинээр баригдах Цэвэр усны станц хүртэл татаж 63кВА КТПН дэд өртөө барьж шинээр баригдсан КТПН дэд өртөөний 6кВ ЦДАШ-наас бүрээстэй агаарын шугамаар шинээр баригдах бохирын станц хүртэл татаж төгсгөлийн тулгуурт хуурай салгуур суурилуулан 100кВА КТПН дэд өртөө барьж ЦЭХ холбох.

Гурав.Тоолуур хэмжих хэрэгсэл:

	Монгол улсын стандарт шаардлагыг хангасан, стандартчилал хэмжил зүйн баталгаажуулалт хийгдсэн "Ховд ЦТС ХХК"-д ашиглаж байгаа ухаалга тоолуурын системд уншигдаг 5-100/А/-ын тоолуур байна.
3.1	63кВА КТПН Дэд станцын толгой Тоолуур нь DTZY88-M 100/A/ Загвартай байх.
3.2	100кВА КТПН Дэд станцын толгой Тоолуур нь DTZY88-M 100/A/ Загвартай байх.

Дөрөв.Тусгай заалтууд:

4.1	Гадна цахилгаан хангамжийн зураг төсөл зохиох явцад "Ховд ЦТС" ХХК-ийн Техник болон борлуулалтын хяналтын инженерүүдтэй зөвшилцөх.
4.2	Техникийн нөхцөл болон зургийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ иж бүрэн туршилтад баталгаажсан байх.
4.3	**КТПН** (Гадаа байршуулах зориулалттай иж бүрдмэл трансформатор дэд өртөө) • 63-100 кВА КТПН • Өндөр талдаа 15А гал хамгаалагчтай • Цэнэг шавхагч ОХУ үйлдвэрлэсэн ОПН маркийн байх • 0.4кВ талдаа 200А 4ш гаргалгаатай

	• Шинээр суурилуулах КТПН-ийн өндөр хүчдэлийн кабель шугамын эхлэлд шугамын хуурай салгуур сууртай нь суурилуулах • Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 63-100 кВА чадалтай 6/0.4, 10/0.4 кВ-ын хүчдэлийн түвшинд шилжин ажилдаг хүчдэл тохируулга нь 5 шатлалтай трансформатор байна
4.4	**Агаарын шугам** • 6-10 кВ хүчдэлтэй агаарын шугамд Монгол улсын стандартад нийцсэн төмөр бетон тулгуурыг хэрэглэнэ. Тулгуурын ашиглалтын хугацаа 40 жилээс багагүй байх ёстой. • 6-10 кВ-ын дамжуулагч утас нь зориулалтын AlSiMg хайлшаар хийсэн СИП ангиллын агаарын шугамын дамжуулагч утас байна. Дан хөнгөн цагаан, гант хөнгөн цагаанаар хийсэн СИП ангиллын агаарын шугамын дамжуулагч утас хэрэглэхийг хориглоно. • Гол болон томоохон авто зам дээгүүр гарч байгаа тохиолдолд 6 кВ-ын тулгуурыг 35 кВ-ын габаритаар хийж гүйцэтгэнэ. • СИП3 ангиллын агаарын шугамын дамжуулагч утас хэрэглэж байгаа тохиолдолд шаазан изолятор нь дундаа ховилтой, мултарч унахаас сэргийлсэн эргүүлдэг резинэн зөөлөвчтэй байна. • Шинээр баригдах Шугам дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК-тай зөвшилцсөн байх, хүлээлгэн өгөх, гүйцэтгэлийн зураг гаргахдаа кабель, шугам, муфтуудыг заасан, бусад инженерийн шугам сүлжээ, авто замтай огтлолцсон хэсгийн зүсэлтийг тусгах. • Дэд өртөөний бүх тоноглол, гаргалгаа кабель шугамууд болон агаарын шугамын тулгуур бүрд НСД, ААД, ТАД-д заагдсаны дагуу хаягжилт, плакатжуулах ажлыг гүйцэтгэсэн байх. • Шинээр баригдах Цахилгаан дамжуулах агаарын шугамын эхэнд богино залгааны гэмтэл заагч датчикийг суурилуулах. Техник шаардлагын тодорхойлолтыг / www.tog.mn хаягаар орж хууль, эрх зүйн акт хавтасны баримт бичиг цонхноос үзэх.
4.5	**Бусад нэмэлтүүд** • Хэрэглэгчид очих эрчим хүчний чанар стандартын шаардлага хангаагүй тохиолдолд хүчдэл өгөх болон техникийн нэмэлт агра хэмжээнүүдийг хангагч байгуулагтай хамтарсан хэмжилт туршилтын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Гарах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна. • Өөрийн дэд станц, шугам тоноглолоос хангчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цахилгаан хангамж хэрэглээг түдгэлзүүлнэ. • Гадны эзэмшлийн шугам тоноглолоос холбогдох тохиолдолд зураг төсөл боловсруулах шатанд эзэмшигчээс зөвшөөрөл авч, зөвшилцсөн байх. • Өвлийн их ачаллын улиралд эрчим хүчний систем горим ажиллагааг хангах үүднээс урьдчилан мэдэгдэлгүйгээр хязгаарлалт хийж болзошгүй тул нөөц их үүсгүүрийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг анхаарна уу. • Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна. • Түгээх сүлэжээний төлөвлөлт, горимын онцгой ач холбогдол бүхий нийтийн сүлжээ, магистраль шугам үүсгэхээр газарт техникийн нөхцөл олгосон тул шинээр баригдах дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, тоноглолоос хангач байгууллага нь горимын найдвартай ажиллагааг хангах зорилгоор бусад иргэн, хуулийн этгээдэд техник нөхцөл олгохыг анхаарна уу.

Тав.Техникийн даалгавар, хууль, дүрмийг мөрдөх:

5.1	Монгол улсын Эрчим хүчний тухай хууль,Засгийн газрын 2001 оны 263-р тогтоолоор батлагдсан Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний зохицуулах хорооны

5.2	Техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам тоноглолууд нь Ховд цахилгаан түгээх ХХК-ны баталсан техникийн шаардлагын тодорхойлолтыг хангасан байх шаардлагатай.
5.3	Дэд өртөө шугамын "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн мэдээллийн санд оруулсан байх.
5.4	Дэд өртөө, шитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
5.5	"Эрчим хүчний тухай" хууль-ийн 30.1.8 д заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнга үзлэг шалгалт хийж хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.
5.6	"Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9, 30.1.10-ийн дагуу нийтийн эзэмшлийн барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам тоноглолийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх. Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.
5.7	Цахилгаан эрчим хүч хэрэглэх гэрээг Ховд ЦТС ХХК-ын борлуулалтын албатай хийж төлбөр тооцоог бүрэн барагдуулж байх. Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллага ХОВД ЦТС ХХК-д хүлгээлгэн өгөх.
5.8	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай бут сөөгийг сэргээн засварлах.

ТЕХНИКИЙН КОМИСС

Дарга: Ерөнхий инженер / Н.Ням-Эрдэнэ /

Гишүүд: Ерөнхий санхүүч / Н.Шинэжил /

БА-ны дарга / Д.Уртнасан /

ТХ-ны инженер / Б.Баатархүү /

АЗА-ны ахлах инженер / Т.Нармандах /

Горимын инженер / П.Мөнхбаатар/

ТТ инженер / Г.Төгстөгөлдөр /

РХА-ын инженер / А.Эрдэнэтогтох /

ХОВД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ
84140 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас/Факс: (976) 7043-2381
Е-мэйл: khovdemg@yahoo.com, khovdemg@gmail.com
http//www.khovdemg.mohs.mn

2025.07.02 № 10-32-02/133/87

"ДӨРВӨНГҮН" ХХК-Д

Зураг төсөлд эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай

Танай компанийн ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт , Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн 5.1.2 хэсэг, Барилга байгууламж барих газрын байршил тогтоох барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийж, дүгнэлт гаргах заавар"-ыг үндэслэн Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Б.Эрдэнэцэцэг би Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын захиалгаар "Дөрвөн гүн" ХХК-ний зурсан Эрдэнэбүрэн сумын нутаг дэвсгэрт баригдах "Сумын төвийн нэгдсэн ариутгах татуургын гадна шугам сүлжээний өөрчлөлт шинэчлэлийн зураг төсөлд 2025 оны 07 сарын 02-ны өдөр эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийлээ.

Зураг төслийн товч агуулга :

Тус сумын төвийн нэгдсэн дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зургийг 2019 онд батлагдсан зураг төслөөс бохир усны шугамын трасс, болон цэвэрлэх байгууламжийн байршлыг өөрчлөн төлөвлөх болсонтой холбоотойгоор нэмэлт өөрчлөлтийн зураг төслийг Ховд аймгийн Засаг даргын орлогчийн 2025 оны 05 сарын 27-ны өдрийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг үндэслэн боловсруулжээ.

Тухайн өөрчлөлтийн зураг төсөлд 1,5 км бохир усны шугам шинээр тусгах, 50 м3 цэвэрлэх байгууламж төлөвлөжээ.

Бохир усны цэвэрлэх байгууламж

Цэвэрлэх байгууламжийн барилга нь тэнхлэгээрээ 11,6м х 4м хэмжээтэй, 1 давхар барилга.

8400025005

Тухайн барилгын ±0.00 түвшинд ажлын тавцан, ариун цэврийн өрөө, насосны өрөө, үйлчилгээний өрөө, 2.40 түвшинд биореактор, 2-р тунгаагуур, халдваргүйжүүлэх төхөөрөмжийн хэсэг, 1-р тунгаагуур, сараалж, биореакторын хэсэг байхаар төлөвлөсөн.

Тус барилгын ус хангамжийн хувьд хяналтын худгаас насосоор ус татан авч суултуурын бочкинд өгнө. Ахуйн хэрэглээний усыг зөөврөөр зөөж хэрэглэнэ. Цэвэр усны шугам нь Ф15мм-ийн /ГОСТ 3262-91/ маркийн цайрдсан ган хоолой байна. Шугам хоолойг ус буулгах цэг рүү 0.003 налуутайгаар угсрах ба хоолойг тосон будгаар 2 дахин будна, бохир ус нь барилгын дотор тавигдах ариун цэврийн тоног төхөөрөмжүүдээс гарах ахуйн бохир усыг сараалж руу зайлуулна. Бохир усны шугам сүлжээнд стандартад нийцсэн PVC маркийн Ф50-100мм-ийн хуванцар хоолойг ашиглана. Шалгах тагийг шалнаас дээш 1.0м-т, агааржуулах хоолойг барилгын дээврээс дээш 0.9м-т байхаар төлөвлөн зурсан.

Барилгын халаалтад цахилгаан радиатор төлөвлөлөө. Халаах хэрэгслийг Герман улсад үйлдвэрлэсэн Eldom наркийн радиатор байхаар сонгож тооцсон. Халаах гадаргуу нь fэ=0.3 ЭКМ болно. Угсралтын үед энэхүү халаах хэрэгслүүдийг техникийн үзүүлэлтүүд нь хангасан өөр халаах хэрэгслээр зохиогчийн зөвшөөрлөөр сольж болно. Тоног төхөөрөмжийн хүчин чадал, яндан хоолойн техникийн үзүүлэлтийг тоног төхөөрөмжийн тодорхойлолт ба материалын түүвэрт үзүүлсэн.

Тус барилгын агаарыг дефлекторээр зайлуулахаар тооцож төлөвлөв. Барилгын ариун цэврийн өрөөнөө зайлуулах агаарыг ЕС-1 ердийн системээр зайлуулна. Агаар дамжуулах хоолой нь ГОСТ19904-75-н цайрдсан гөлмөн төмөр байх ба ханын зузааныг БНбаД 41-01-11-н" хавсралтын дагуу сонгоно. Барилгын дээврээс доош гарсан хэсгийг пенополиуретан материалаар дулаална. Агаар зайлуулах хоолойг барилгын дээврээс дээш 0.7м-ээс багагүй өндөрт гаргах ба хоолойн төгсгөлд зонт байрлуулна гэж зургийн тайлбарт тусгажээ.

<u>Цэвэрлэх байгууламжийн технологийн зарчим</u>

Цэвэрлэгдсэн ус шүүх талбайгаар дамжин байгальд нийлүүлэгдэх ба энэ нь бохир усыг Монгол улсын стандарт MNS 4943.2015 -ийн шаардлагыг хангана.

<u>Хүлээн авах худаг</u>

Хүлээн авах худаг нь цэвэрлэх байгууламжид ирж байгаа бохир усны даралтыг бууруулах, урсгалын хурдыг сааруулах үндсэн чиг үүрэгтэй. Хэрэв бохир ус цэвэрлэх байгууламжийн гар ажиллагаатай сараалжинд өөрийн урсгалаар ирэх боломжтой тохиолдолд хүлээн авах худгийг төлөвлөхгүй байж болно.

Гар ажиллагаатай сараалж

Хүлээн авах худаг нь цэвэрлэх байгууламжид ирж байгаа бохир усны даралтыг бууруулах, урсгалын хурдыг сааруулах үндсэн чиг үүрэгтэй. Хэрэв бохир ус цэвэрлэх байгууламжийн гар ажиллагаатай сараалжинд өөрийн урсгалаар ирэх боломжтой тохиолдолд хүлээн авах худгийг төлөвлөхгүй байж болно.

Ган их бие бүхий биоректор

Орчин үед цэвэрлэх байгууламжийг ган хийцээр төлөвлөх нь түгээмэл болсон бөгөөд энэ нь овор хэмжээ багатайгаас гадна угсралт суурилуултын ажлыг хийж гүйцэтгэхэд илүү хялбар болгодог. Цэвэрлэх байгууламжийн үндсэн их бие болох ган сан нь 0245 маркийн 5 мм зузаантай гангаар хийгдсэн бөгөөд гадна талыг босоо туузан төмрөөр хүчжүүлж, цүлхийлтээс хамгаалсан байна. Уг их биеийн эд ангиудыг ган усан сан үйлдвэрлэдэг гадаад дотоодын үйлдвэрээс авах ба төслийн байршилд угсралтын ажлыг зохих технологи зааврын дагуу гагнаж, угсарч суурилуулна. Ган их бие дотор технологийн дараалаар доорх сангууд байрлана. Үүнд:

- 1-р тунгаагуур
- Биореактор
- 2-р тунгаагуур
- Халдваргүйжүүлэх сан

1-р тунгаагуур

1-р тунгаагуур нь элс шороо, тос зэргийг тунгаах үндсэн үүрэг гүйцэтгэнэ. Доор тунасан элсийг тодорхой хугацаанд лагийн талбай руу эрлифтийн тусламжтайгаар гаргаж хаяна. Хөвсөн тос нь нүдэнд харагдаж байдаг тул туршилт тохируулгын ажилтны гаргасан заавар аргачлалын дагуу цэвэрлэж зайлуулна.

Биореактор

Биореактор нь агааргүй ба агаартай орчин гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Агааргүй орчинд Денитрификацын явагдах ба агаартай орчин буюу аэротенкэд нитрификацийн процесс явагдаж умбуур бодис цэвэрлэгдэнэ. Аэротенкийн нийт эзлэхүүнд хиймэл замаг байрлуулах ба энэ нь цэвэрлэгээний явцыг жигд бөгөөд нягтаршил ихтэйгээр явагдах нөхцөлийг бүрдүүлдэг. Аэротенкэд агааржуулалтыг агаарын компрессор болон диффузорын тусламжтайгаар хийнэ. Аэротенк нь цувран байрлах 2 сангаас бүрдэх бөгөөд энэ нь тухайн цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөхөд хялбар байхаар төлөвлөгдсөн шийдэл юм.

2-р тунгаагуур

2-р тунгаагуур нь урсгалын хурдыг багасгах замаар лагийг тунгааж цэвэрлэгдсэн усыг ялгах үндсэн үүрэг гүйцэтгэнэ. 2-р тунгаагуурт тунасан лагийг эрлифтийн тусламжтайгаар биореакторт эргүүлэн өгч цэвэрлэгээний үйл явцын тохируулгад ашиглана. Хуримтлагдаж ихэссэн илүүдэл лагийг эрлифтийн тусламжтайгаар лагийн талбайд хаяна.

Халдваргүйжүүлэх сан

Халдваргүйжүүлэх сан нь ган савны төгсгөлийн хэсэгт байрлах бөгөөд 2-р тунгаагуурын халиах сувгаар дамжин ирсэн цэвэрлэгдсэн усыг хүлээн авч хэт ягаан туяаны төхөөрөмжөөр халдваргүйжүүлнэ.

Хяналтын худаг

Халдваргүйжүүлэх сангаас гарсан ус нь хяналтын худагт ф76 ган хоолойгоор ирнэ. Уг сан нь цэвэрлэгдсэн усны чанарын хяналтын дээж авах үндсэн зориулалттай.

Биоцөөрөм

Хяналтын худгаас гарсан ус ф108-ийн ган хоолойгоор дамжин шүүх талбайд ирнэ. Шүүх талбай /биоцөөрөм/ нь өөрөө цэвэрлэх явцад үүсдэг процессын үндсэн дээр сул шүүлтүүртэй хөрсөн дээр бохир усыг биологийн аргаар цэвэршүүлдэг зохиомлоор бий болгосон гүехэн усан сангууд юм. Шүүх талбайг бусад биологийн цэвэрлэх байгууламжуудаар дамжин өнгөрсний дараа бохир усыг цэвэрлэхэд ихэвчлэн ашиглах ба 0,6-1,2 метрийн гүнтэй байна. Шүүх талбайгаас гарсан усыг байгальд шууд нийлүүлэх ба урсах сувгийн дагуу мод ургамал үрслүүлж, тарихад тохиромжтой талбай үүсэх давуу талтай гэж зураг төсөлд тусгажээ.

Инженер геологийн судалгааны талаар: Инженер геологийн судалгааг “Монгео-экотех”ХХК-ний 2025 онд хийсэн. Тус судалгаагаар уг газрын хөрс нь инженер геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй талбайд хамаарана гэжээ.

ДҮГНЭХ НЬ:

1.Эрдэнэбүрэн сумын “Сумын төвийн төвлөрсөн ариутгах татуургын гадна шугам сүлжээний” өөрчлөлт шинэчлэлтийн зураг төсөл нь Монгол Улсын “УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ГАДНА СҮЛЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БНбД 40-04-16 -ын шаардлага хангаж байна.

Зураг төсөлд дараах өөрчлөлтийг оруулах саналтай байна.Үүнд:

1. Монгол Улсын “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн 17.4.2, 17.6, 17.7, 18.2.4.дэх заалтуудад тусгасан хамгаалалтын зурвастай байхаар төлөвлөх.

2. Цэвэрлэх байгууламжийг төлөвлөхдөө Аймгийн Байгаль орчны газраас нөлөөллийн үнэлгээг хийлгүүлэх

"Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 - д зааснаар: Шалгуулсан байгууллага , аж ахуйн нэгжийн эрх баригч , албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн , гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана.

ДҮГНЭЛТ БИЧСЭН:

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ДҮГНЭЛТИЙГ ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ЗАХИРАЛ Ч.МАНЛАЙБААТАР

БАРУУН БҮСИЙН ТӨВ-ХОВД АЙМГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
**БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ
ХИЙСЭН ТУХАЙ ДҮГНЭЛТ**
Жаргалант сум, Ховд аймаг,
Утас: 7043101, 70433801
Цахим шуудан: khovd@nema@gmail.com
2025.06.26 № 096/30.

"ДӨРВӨНГҮН" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ч.МАНЛАЙБААТАР
ТАНАА

ДҮГНЭЛТ ОЛГОХ ТУХАЙ

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил: Ховд аймаг, Эрдэнэбүрэн сум

2. Зургийн шифр, зураг төслийн компани: "ДӨРВӨНГҮН" ХХК, DG-17/2025 ажлын зураг

3. Барилга байгууламжийн зориулалт: Ховд аймаг, Эрдэнэбүрэн сум, Сумын төвийн нэгдсэн ариутгах татуургын гадна шугам сүлжээ /Өөрчлөлт шинэчлэл/, 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн барилга байгууламжийн зураг төсөлд өөрчлөлт оруулах ажлын даалгавар, Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, ЗГ-ын 2021 оны 161 дүгээр тогтоолын хавсарт.

4. Барилга байгууламжийн багтаамж, куб.м, давхар: Тэнхлэгээрээ 4,0х10м хэмжээтэй, 1 давхар барилга, Захиалагч: "Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын засаг дарга"

5. Гал тэсвэршилтийн зэрэг: Төлөвлөсөн II, Газар хөдлөлтийн 9 балл, салхины ачаалал 45 кг/м^2, цасны ачаалал 50 кг/м^2, гадна агаарын тооцоо температур -44^{0}С

6. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф5

7. Зургийн иж бүрдэл: 1 хэсэг

**Хоёр: Барилга байгууламжийн зураг
төслийн галын аюулгүй байдал**

1. Барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг Монгол улсын барилгын норм ба дүрмийн БНбД 21-01-02 баримтлан ажиллах.

2. Барилгын зураг төслийг төлөвлөхдөө Хот суурин төлөвлөлт барилгажилтийн БНбД 30-01-04 норм ба дүрмийг баримтлах.

3. Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах /MNS5566:2020/ стандартын дагуу үйлчилгээ явуулдаг өрөө тасалгаанд гал унтраагуур байрлуулж, галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, аврах гарцын тэмдэг тэмдэглэгээ бичиж байрлуулах.

Гурав: Ерөнхий дүгнэлт

Дээрхи шаардлагыг биелүүлснээр тус барилгын ажлын зураг нь тухайн объектын галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа болно. /Ажлын зураг дээр зөвшилцөн засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай/

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Он, сар, өдөр	Тэмдэг дарсан хуудасны дугааруд	Нэмэлт тэмдэглэл
2025.06.26	Нүүр хуудас	Барилгын зураг төслийг дүгнэлтийн дагуу хийж гүйцэтгэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
АХМАД А.ОЮУНЖАРГАЛ